



Г ХӨЛӨНБҮЙР СУМЫН МОНГОЛ 7
АРДЫН НАМЫН ХОРООНЫ ДАРГА
Ю.ЦЭПЭЛМАА ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.04.28 № 460
таний 2025.04.16 -ны № 01 -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд 1
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хөлөнбүйр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох Хөлөнбүйр сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аudit MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөлөнбуйр сумын Монгол ардын намын Хөлөнбуйр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хөлөнбуйр сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр долоон хуудас хавсаргав.

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 7 хуудастай.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink, appearing to read "Б. БОЛОРТУУЛ".

Б.БОЛОРТУУЛ

**ХӨЛӨНБҮЙР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ 2024 – 2028 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Хөлөнбүйр сумын Монгол Ардын намын хорооны 2024-2028 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийг 4 бодлогын 16-н бүлгийн хүрээнд нийт 54 зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлж байна. Үүнд:

НЭГ: ТӨРИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- 1.1. Нутгийн удирдлагын хүрээнд:
- 1.2. Гадаад харилцааны чиглэлийн хүрээнд:
- 1.3. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хүрээнд:
- 1.4. Хууль хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:
- 1.5. Батлан хамгаалах салбарын хүрээнд:
- 1.6. Гамшигаас хамгаалах бодлогын хүрээнд:

ХОЁР: НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- 2.1. Эрүүл мэндийн салбарын хүрээнд:
- 2.2. Боловсрол, соёл, урлаг, спортын салбарын хүрээнд:
- 2.3 Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг зорилtot бүлэгт чиглэсэн төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, нийгмийн харилцаанд адил тэгш оролцох боломжоор хангах ажлын хүрээнд:
- 2.4. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих суурь нөхцөлийг бий болгох ажлын хүрээнд:

ГУРАВ: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- 3.1. Малын үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг зөв зохистой өсгөх, шинэ технологи нэвтрүүлэх.
- 3.2. Байгаль орчинд сөрөг нэлөөгүй дэвшилтэт технологид сууринсан газар тариаланг хөгжүүлэх.
- 3.3. Жижиг дунд үйлдвэрлэл, шинэ технологи, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 3.4. Сумын төвийн газрын ус, дулаан хангамж, хүн амын тохитой, хоггүй цэвэр, эмх цэгцтэй, ногоон байгууламжтай орчинд амьдрах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.5. Төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж төсвийн байгууллагын албан хаагч болон иргэд төсвөө хянах, төсвийн харилцаанд оролцох боломжийг бүрдүүлэх зорилтыг хангана.

**ДӨРӨВ: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 4.1 Байгаль орчныг хамгаалах, унаган төрх, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, хомсдоос сэргийлэх, байгаль орчинд нийцтэй бодлого хэрэгжүүлнэ.

НЭГ: ТӨРИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Иргэнээ дээдэлсэн нутгийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлж, төрийн албаны чадавх, хариуцлага, хяналтын тогтолцоог сайжруулж, гадаад харилцааны үр нөлөө хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

1.1. Нутгийн удирдлагын хүрээнд:

- 1.1.1. Иргэдийн санал хүсэлт, зөвлөмжийг сонсож, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон нээлттэй төрийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор иргэд хүлээн авах төвийн үйл ажиллагааг тогтмолжуулан, "Иргэдтэй уулзах өдөр", "Нээлттэй хаалганы өдөр" арга хэмжээг цаашид үргэлжлүүлэн зохион байгуулна.
- 1.1.2. Төрийн үйл ажиллагааг хөнгөн шуурхай ил тод нээлттэй хүргэх зорилгоор төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрээр иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад хүргэж төрийн үйлчилгээний хурд, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.3. Суманд хэрэгцээт шаардлагатай мэргэжилтэн, ажилчдыг бэлтгэх ажлыг бодлогоор дэмжин ажиллана.
- 1.1.4. Төрийн байгууллагуудын ажил, үйлчилгээ, албан хаагчдын ажлын байрны чиг үүргийг ил тод болгон үр дүнг иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээнд тулгуурлан үнэлж, ёс зүй –хариуцлагын тогтолцоог сайжруулна.

1.2. Гадаад харилцааны чиглэлийн хүрээнд:

- 1.2.1. БНХАУ-ын ӨМӨЗО-ы ШБЗХ-тай харилцан хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлж, харилцан айлчлал хийж аялал жуулчлал, урлаг спорт, соёлын хамтын ажиллагааг үргэлжлүүлж, шинэ гарцыг судалж гадаад харилцаагаа өргөжүүлж ажиллана.

1.3. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хүрээнд:

- 1.3.1. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар иргэдийн сэтгэл ханамжийг судлан, үр дүнг тооцож ажиллана
- 1.3.2. Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд хөндлөнгийн мониторинг хийж үйл ажиллагааг нь сайжруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллана.
- 1.3.3. Төсвийн сахилга батыг сайжруулахад анхаарч төсвийн болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулна.

1.4. Хууль хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

- 1.4.1. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн албан болон албан бус сургалтыг иргэд олон нийт болон төрийн албан хаагчдад үе шаттайгаар зохион байгуулна.

- 1.4.2. Сумын дундын Цагдаагийн тасагтай болсонтой холбогдуулан цагдаагийн кубоны өргөтгөлийн барилга барих, алба хаагчдын ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.4.3. Захиргааны байгууллагын шийдвэр боловсруулах ажиллагаа болон шийдвэрлэсний дараах хэрэгжилтийг зохион байгуулах ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд ханганд ажиллана.
- 1.4.4. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Архигүй амьдрал” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор зорилтот бүлгийн иргэдийг архины сайн дурын болон албадан эмчилгээнд үе шаттайгаар хамруулна.
- 1.4.5. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам ахиулах ажилд иргэд байгууллагын оролцоог нэмэгдүүлж гэмт хэргийн гаралтыг бууруулах ажлыг удирдлага, бодлого, зохион байгуулалтаар ханганд ажиллана.
- 1.4.6. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, урамшуулалтай малчдын бүлэг холбоод байгуулах шийдвэрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан ажиллана.
- 1.4.7. Архивын баримт бичгийн 80 хувийг цахим хэлбэрт шилжүүлэх замаар төрийн архивын хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авна.
- 1.4.8. Хүний эрхийн Үндэсний Комисс болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран иргэд, олон нийтэд хууль сурталчлан тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх замаар хүний эрхийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд ханганд ажиллана.

1.5. Батлан хамгаалах салбарын хүрээнд:

- 1.5.1. Батлан хамгаалах салбарын бодлого, зорилт, шийдвэрийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулан сурталчилж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

1.6. Гамшгаас хамгаалах бодлогын хүрээнд:

- 1.6.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд шаардагдах гал унтраах болон аврах ажиллагааны техник багаж хэрэгслийн бааз бүрдүүлэх, гамшгийн эрсдлийн сан байгуулан ажиллана.

ХОЁР: НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1. Эрүүл мэндийн салбарын хүрээнд:

Хүн амыг өвчинөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал, хандлагыг төлөвшүүлж нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж үйлчилгээг сайжруулж, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлнэ.

2.1.1. Эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлж, эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх

2.1.2. Хүүхэд, ахмад настны эрүүл мэндийн сувилал, асаргааг тогтмол зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

2.1.3. Эрүүл мэндийн төвийн барилгыг өргөтгөж иргэдэд үйлчлэх хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2. Боловсрол, соёл, урлаг, спортын салбарын хүрээнд:

Хүүхэд бүрийн сурч хөгжих таатай орчныг бүрдүүлж, сургалтын чанарыг ахиулан, хамтын ажиллагааг өргөжүүлж хүүхдэд ээлтэй сум болно.

2.2.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдэд уламжлалт зан заншил, өв соёл, түүхээрээ бахархдаг, эх оронч сэтгэлгээ, үнэт зүйлтэй болгон төлөвшүүлэх тэдний хөгжлийг дэмжсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хичээлийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх.

2.2.2. Боловсрол, соёл урлагийн байгууллагын бүх шатны боловсон хүчиний тогтворт суурьшилтай ажиллах, мэдлэг чадвараа дээшлүүлэх, тасралтгүй хөгжих нөхцөл боломжийг нэмэгдүүлэх зорилгоор туршлага судлах, мэргэжлийн чиглэлээр бус, улс, олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.

2.2.5. Цэцэрлэг, сургуулийн бусэд шаардлагатай хэрэглэгдэхүүн, сургуулийн хүүхдийн хүнсний агуулах, хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг үе шаттайгаар зохион байгуулж хэрэгжүүлнэ.

2.2.6. Албан бус насан туршийн боловсролын төвийг тохижуулах, өсвөр үе, залуучуудын ёс суртахуун, гоо зүйн мэдрэмж төлөвшил, иргэний боловсрол, амьдрах ухааны чадварыг нэмэгдүүлэх нөлөөллийн үйл ажиллагаанд бодлогоор дэмжин ажиллана.

2.2.7. Сумын соёл урлагийн байгууллагын халаалтын системийг өргөтгөх, барилга байгууламжийн их засварыг үе шаттайгаар зохион байгуулна.

2.2.9. “Түнх” сурын харвааг сурталчлан, хөгжүүлэх ажлыг бодлогоор дэмжин ажиллана.

2.3 Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, нийгмийн харилцаанд адил тэгш оролцох боломжоор хангах ажлын хүрээнд:

2.3.1. Залуучуудыг олон нийтийн үйл ажиллагаанд оролцох боломж бүрдүүлэх зорилгоор залуучуудын дунд спорт, урлагын бага наадмыг уламжлал болгон зохион байгуулах, шилдэг залуу гэр бүлийг тодруулах үйл ажиллагааг хувийн хэвшил, олон нийтийн байгууллагын дэмжлэгтэйгээр байгуулна.

2.3.2. Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулж санаачлагч, зөвлөн туслагч, баялаг бүтээгч болгох “Ахмадаа ачлах” хөтөлбөр болон “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг үр дүнтэй үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж ахуй эрхлэлтийн болон хувиараа хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад хамруулж, ажлын байраар хангахад анхаарч ажиллана.

2.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эмчилгээ сувилгаанд хамрагдахад дэмжлэг үзүүлж ажиллана.

2.3.5. Нийтийн биеийн тамирыг дэмжиж өсвөр үе, хүүхэд, залуучууд, ахмад, настанд зориулж хороолол бүрт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх спортын цогц талбайтай болгох ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.

2.4. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих суурь нөхцөлийг бий болгох ажлын хүрээнд:

2.4.1. Орлого багатай болон хувиараа аж ахуй, бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг ажлын байр, түрээсийн хөнгөлөлт болон орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудын хэрэгцээнд давуу эрхтэйгээр нийлүүлэх, бодлогоор дэмжинэ.

ГУРАВ: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Тогтвортой эдийн засагтай, тэргүүлэх хөгжилтэй сум болно.

3.1. Малын үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг зөв зохистой өсгөх, шинэ технологи нэвтрүүлэх.

3.1.1. Малын тоо, сүргийн бүтцийн зохистой харьцааг баримталж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхтай малын тоог нэмэгдүүлнэ.

3.1.2. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, малчдын саналд тулгуурлан худаг гаргах, сэргээн засварлах арга хэмжээг хэрэгжүүлж, гэрээ байгуулан хамтран ашиглах боломжийг бүрдүүлж, ашиглалтанд хяналт тавина.

3.1.3. Хадлангийн талбайг зөв зохистой ашиглах “Бэлчээр, хадлан тэжээлийн талаар баримтлах бодлогын баримт бичи”-ийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих замаар хадлан бэлтгэлийг, нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг бүрэн хангана.

3.1.4. Хоршоо, фермерүүдийн үйл ажиллагааг дэмжиж, түүхий эд бэлтгэн нийлүүлэх, бүтээгдэхүүн борлуулах оновчтой сүлжээг бий болгоход хөдөө аж ахуйн бирж, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.

3.1.5. “Бэлчээрийн ашиглагчдыг хариуцлагажуулах” журмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллана.

3.2. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй дэвшилтэт технологид суурилсан газар тариаланг хөгжүүлэх.

3.2.1. Газрын нөөц, боломжид тулгуурлан сумын атар болон атаршсан талбайг сэргээн тариалалт хийж, үр тарианы үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, Газар тариалангийн баримтлах бодлогыг хэрэгжүүлэн ажиллана.

3.3. Жижиг дунд үйлдвэрлэл, шинэ технологи, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

3.3.1. Суманд үр тария, хүнсний ногоо, малын тэжээл тариалах, үйлдвэрийн аргаар хорголжин, багсармал тэжээл бэлтгэх, төл, малын арьс элдэх, анхан шатны боловсруулалт хийх цех үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

3.3.2. Хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлж нэгдсэн зохион байгуулалтад оруулан, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, хүлэмжийн тариалалтад жил бүр нийт өрийн 10 хувийг хамруулах ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.

3.3.3. Сумын хөгжлийн сангийн зээлийг нээлттэй төсөл сонгон шалгаруулах замаар олгож, ажлын байр бий болгож нийгмийн даатгалын шимтгэлийг баталгаажуулна.

3.4. Сумын төвийн газрын ус, дулаан хангамж, хүн амын тохитой, хоггүй цэвэр, эмх цэгцтэй. Цэвэр агаартай ногоон байгууламжтай орчинд амьдрах суурь нөхцлийг бүрдүүлнэ.

3.4.1. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хувийн тохилог орон сууц барих хоткон хорооллын газрыг олгож, инженерийн шугам сүлжээг байгуулах нөөц боломжийг судалж үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.

3.4.2. Сумын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг хийж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан газар зохион байгуулалтын ажлыг үе шаттайгаар төлөвлөж ажиллана.

3.4.3. Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчний гэрлээр өргөтгөх, тохижуулах, цахилгааний шугамыг өргөтгөх, шинэчлэх ажлыг үе шаттайгаар төлөвлөж зохион байгуулна.

3.4.4. Засаг Даргын Тамгын Газрын байрыг шинээр барих, Хоолон гэр /123/-ын уулзвараас сумын төв дундуур 2.1 км урттай засмал зам тавих ажлыг эдийн засгийн боломжид тулгуурлан судалж шийдвэрлэнэ.

3.4.5. Хөдөөгийн багуудыг багийн төвтэй болгож, төвүүдийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлж, байнгийн үйл ажиллагаатай болоход бодлогоор дэмжин ажиллана.

3.5. Татварын бааз суурийг нэмэгдүүлэн, төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлэн ил тод байдлыг хангаж, орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагааг сайжруулна.

3.5.1. Мэргэжлийн байгууллагуудын зөвлөмж дүгнэлтийг хэрэгжүүлэх зорилгоор төсөвт байгууллагуудад ашиглагдаж байгаа санхүүгийн программыг бүрэн ашиглаж хэвшүүлэх, Төсвийн сахилга батыг сайжруулах, дотоод хяналтыг чангатгах, төсвийн харилцааг бүх шатанд ил тод, нээлттэй байх зарчмыг сайжруулах зорилгоор шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.5.2. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй хариуцлагатай байх зарчмыг хангах зорилгоор иргэдийн оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллана.

ДӨРӨВ: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4.1 Байгаль орчныг хамгаалах, унаган төрх, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, хомсдоос сэргийлэх, байгаль орчинд нийцтэй бодлого хэрэгжүүлнэ.

4.1.1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх бодлого”-ын баримт бичгийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, ой, хээрийн түймэр гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зурvas байгуулан, намар, хаврын улиралд сэргээн сайжруулна.

4.1.2. Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг мэргэжлийн байгууллагын судалгаанд үндэслэн зохистой ашиглах, хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.

4.1.3. “Цэвэр орчин” төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.1.4. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөн”-д тусгагдсаны дагуу аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар бодлогоор дэмжин ажиллана.

4.1.5. Сумын төвийн цөлжилтийг арилгах зорилгоор мод тарих ажлыг иргэд олон нийтийн оролцоотой зохион байгуулж, цэцэрлэгт хүрээлэнг нэмэгдүүлэнэ.

ХӨЛӨНБҮЙР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

